



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 02 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

“Өршөөл үзүүлэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тайлбарлах тухай

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн /цаашид “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн гэх/ 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүний эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан журмаар өршөөн хэлтрүүлэх эсэх асуудлыг шат шатны шүүх өөр өөрөөр тайлбарлан хэрэглэж, өршөөн хэлтрүүлсэн, эсхүл өршөөлд хамааруулахгүй шийдвэрлэсний улмаас шүүхийн практикт хууль хэрэглээний зөрүүтээ байдал үүссэн нь анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрүүдээр илэрсэн байна.

Тухайлбал, Улсын дээд шүүхийн эрүүгийн хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 282 болон 285 дугаар тогтоолоор шүүгдэгч К.С, Б.Н нарт анхан шатны шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар оногдуулсан торгох ялыг “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт зааснаар тус тус өршөөн хэлтрүүлсэн бол Улсын дээд шүүхийн эрүүгийн хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор шүүгдэгч Г.Н-д анхан шатны шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар оногдуулсан торгох ялыг “Өршөөл үзүүлэх тухай” хуульд хамааруулахгүйгээр зөрүүтээ шийдвэрлэжээ.

Иймд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор шүүхийн шийдвэр, практикт үндэслэн “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах хэрэгцээ, шаардлага үүссэн, энэ талаар Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимаас гаргасан саналыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж, тайлбарын цар хүрээ, тайлбар гаргах арга зүйг зөвшөөрсөн бөгөөд “Өршөөл үзүүлэх тухай” хууль болон хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлал, уг хуулийн төслийг хэлэлцсэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Хууль зүйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэл, “Өршөөл үзүүлэх тухай” хуулийг хэрэглэсэн шүүхийн шийдвэрүүдэд Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс хийсэн судалгааны дүнг тус тус харьцуулан шинжилж үзэхэд дараах нөхцөл байдал тогтоогдов.

1.Хууль тогтоогч “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 6.1, 6.2, 6.3, 7.1, 7.2, 7.3, 9.1, 9.2-т зааснаас бусад гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн ялтны шүүхээс оногдуулсан, эсхүл эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг өршөөн хэлтрүүлнэ” гэж өршөөлд хамрагдах болон хамааруулахгүй гэмт хэргийг тодорхой заажээ.

2.“Өршөөл үзүүлэх тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт оногдуулсан ялыг бүхэлд нь өршөөн хэлтрүүлэхгүйгээр ялтны шүүхээс оногдуулсан хорих ялын эдлээгүй үлдсэн хэсгийг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольж эдлүүлэхээр заахдаа уг зохицуулалтын зорилгыг “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор” гэж нарийвчлан тодорхойлсон байна.

3.Өршөөлд хамааруулахгүй гэмт хэрэг, эрүүгийн хариуцлагын төрлийг “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн Гуравдугаар бүлгийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3 дахь хэсэгт тусгайлан зааснаас гадна урьд нь гэмт хэрэг үйлдэж, 1991-2015 оны хооронд батлагдсан 6 удаагийн “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн аль нэгэнд хамрагдан хорих ялаас чөлөөлөгдсөнөөс хойш санаатай гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн хүнийг өршөөлд хамааруулахгүй болохыг уг хуулийн Нэгдүгээр бүлгийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт хуульчилжээ.

Ийнхүү хууль тогтоогч “Өршөөл үзүүлэх хэлбэр, хүрээ, хэмжээ”-г тодорхойлсон 4 дүгээр зүйл /Эрүүгийн хариуцлагаас өршөөн хэлтрүүлэх/ болон 5 дугаар зүйл /Зарим хугацаа болон эрүүгийн хэргийг өршөөн хэрэгсэхгүй болгох/-д “Энэ хуулийн 6.1, 6.2, 6.3, 7.1, 7.2, 7.3, 9.1, 9.2-т зааснаас бусад гэмт хэрэг...” гэсэн хууль зүйн техник ашиглахдаа дээрх зүйлүүдэд заасан өршөөлд хамаарахгүй зарим гэмт хэргийг уг хуулийн Гуравдугаар бүлэг /Өршөөлд хамааруулахгүй нөхцөл/-т давхар зохицуулаагүй орхигдуулсан нь шүүхийн практикт ойлгомжгүй байдлыг бий болгосон.

Өөрөөр хэлбэл, “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсгээр хориглоогүй боловч 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүний эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг уг хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу өршөөн хэлтрүүлэх үндэслэлтэй эсэх талаар хууль зүйн маргаан үүсч, хууль хэрэглээний зөрүүтээ байдал үүссэн байна.

Дээр дурдсан нөхцөл байдлыг үндэслэн “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлд заасан “Энэ хуулийн 6.1, 6.2, 6.3, 7.1, 7.2, 7.3, 9.1, 9.2-т зааснаас бусад гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн ялтны шүүхээс оногдуулсан, эсхүл эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг өршөөн хэлтрүүлнэ” гэдэгт уг хуулийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүний эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг өршөөн хэлтрүүлэхийг багтаан ойлгож хэрэглэх эсэх талаар албан ёсны тайлбар гаргах хэрэгцээ, шаардлага бодитой үүссэн болно.

“Өршөөл үзүүлэх тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүний эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг уг хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу өршөөн хэлтрүүлэх үндэслэлтэй эсэхийг хууль тогтоогчийн санаа зорилго болон системчлэн тайлбарлах аргад тулгуурлан дүгнэлт хийвэл холбогдох хэм хэмжээний агуулгыг тодорхойлох боломжтой юм.

Монгол Улсын Их Хурлаас “Өршөөл үзүүлэх тухай” хуулийг батлан гаргахдаа хуулийн зорилтыг “Тулгар төр байгуулагдсаны 2230 жил, Их Монгол Улсын 815 жил, Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан хүмүүнлэг, энэрэнгүй ёсны зарчмыг удирдлага болгон коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор зарим гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлага, зөрчлийн шийтгэлээс нэг удаа өршөөн хэлтрүүлэх, чөлөөлөх, хасах, ялын төрлийг солихтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” хэмээн тодорхойлж, улмаар уг хуулийн Хоёрдугаар бүлэгт “Өршөөл үзүүлэх хэлбэр, хүрээ, хэмжээ”-г хуульчлахдаа өршөөлд хамаарах гэмт хэргийг “Энэ хуулийн 6.1, 6.2, 6.3, 7.1, 7.2, 7.3, 9.1, 9.2-т зааснаас бусад гэмт хэрэг” гэж тодотгон заасан нь хуулийг хэлэлцэн батлах үед хууль тогтоогчийн баримталсан хүсэл зориг мөн болох нь хуулийн төслийг хэлэлцсэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Хууль зүйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээр тогтоогдсоноос гадна энэхүү хууль тогтоогчийн үзэл санаа хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлалд тусгагдсан байна.

Тухайлбал, Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн төслийн үзэл баримтлалд “...ФАТФ-ын зөвлөмжийн 3, 5, 35 болон шууд хэрэгжилтийн 7-д нийцүүлэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, татвар төлөхөөс зайлсхийх, хулгайлах, дээрэмдэх, залилах, хөрөнгө завших, хүрээлэн байгаа орчны эсрэг зэрэг гэмт хэргүүдийг өршөөлд хамааруулахгүй байхаар тусгана” хэмээн заасныг уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “энэ хуулийн 6.1, 6.2, 6.3, 7.1, 7.2, 7.3, 9.1, 9.2-т зааснаас бусад гэмт хэрэг” гэж хуульчилж, өршөөлд хамаарах болон хамаарахгүй гэмт хэргийг ялган тодорхойлжээ.

Харин хууль тогтоогч хууль батлан гаргах үеийн нөхцөл байдал, нийгмийн хэрэгцээ шаардлагыг харгалзан “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн зорилтод “...коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор ... зарим гэмт хэрэг ... үйлдсэн хүний ялыг ... өөр төрлийн ялаар солихтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” хэмээн тодорхойлсон нь уг хуулийн 7 дугаар зүйл “Хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн солих” гэсэн хэм хэмжээгээр хэлбэржсэн байна.

Өөрөөр хэлбэл, хорих ангид ял эдэлж буй ялтны бөөгнөрлийг сааруулах замаар коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэхийн тулд “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн хүний эдлээгүй үлдсэн ялыг бүхэлд нь өршөөн хэлтрүүлэхгүйгээр, зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольж эдлүүлэхээр зохицуулсан нь тухайн гэмт хэрэгт хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн бусад хүний ялыг “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлд заасан журмаар өршөөн хэлтрүүлэх утга санааг агуулаагүй бөгөөд ийм тухайлсан зохицуулалт уг хуульд байхгүй болно.

Эрүүгийн эрх зүйн хууль ёсны зарчмын хувьд авч үзвэл “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн хэм хэмжээний утга санааг агуулгаас нь дэлгэрүүлэн тайлбарлаж, төсөөтэй хэрэглэж болохгүй.

“Өршөөл үзүүлэх тухай” хуульд хамаарах болон хамаарахгүй гэмт хэргийг 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “энэ хуулийн 6.1, 6.2, 6.3, 7.1, 7.2, 7.3, 9.1, 9.2-т зааснаас бусад гэмт хэрэг” гэж ялган хуульчилсныг уг хуулийн зорилт, хууль тогтоогчийн үзэл баримтлал, хуулийн зохицуулах зүйлийн хэмжээ, хязгаарыг

тогтоосон бусад хэм хэмжээтэй харьцуулан системчилж үзэхэд уг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүний эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг уг хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу өршөөн хэлтрүүлэх агуулгагүй байна.

Иймд “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан “... бусад гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн ялтны шүүхээс оногдуулсан, эсхүл эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг өршөөн хэлтрүүлнэ.” гэдэгт уг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2-т заасан гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүн хамаарахгүй гэж ойлгох нь зүйтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.4-т заасныг удирдлага болгон “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан “... бусад гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн ялтны шүүхээс оногдуулсан, эсхүл эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг өршөөн хэлтрүүлнэ” гэснийг

ТАЙЛБАРЛАХ нь:

1.“Өршөөл үзүүлэх тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2-т заасан гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүний эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан журмаар өршөөлд хамааруулахгүй гэж ойлгон хэрэглэнэ.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ШҮҮГЧ

Б.БАТЦЭРЭН

2021 ОНЫ ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ,
ЗААЛТЫГ ТАЙБАРЛАХТАЙ ХОЛБООТОЙ БАРИМТ,
МАТЕРИАЛ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН ТЭМДЭГЛЭЛ

2022.03.03

Улаанбаатар хот

1. Өршөөл үзүүлэх тухай хууль;
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230623797791>
2. Улсын Их Хурлын нэгдсэн чуулган тэмдэглэл /2021.07.02/
<http://parliament.mn/files/130374>
3. Хууль зүйн байнгын хорооны тэмдэглэл /2021.06.30/
<http://parliament.mn/n/6rzyn>
4. Өршөөл үзүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн судалгаа; /PDF файл/
5. Өршөөл үзүүлэх тухай хуулийн танилцуулга; /PDF файл/
6. Өршөөл үзүүлэх тухай хуулийн үзэл баримтлал; /PDF файл/
7. 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 282 дугаар К.С-д холбогдох хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол;
https://shuukh.mn/single_case/3029?daterange=2021-01-01%20-%202022-03-03&id=3&court_cat=2&bb=1
8. 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 285 дугаар Г.Н-д холбогдох хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол;
https://shuukh.mn/single_case/3047?daterange=2021-01-01%20-%202022-03-03&id=3&court_cat=2&bb=1

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН:
ХҮЛЭЭН АВСАН:

П.ТУЛГА
Х.АМАРБАЯСГАЛАН

ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Тулгар төр байгуулагдсаны 2230 жил, Их Монгол Улсын 815 жил, Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан хүмүүнлэг, энэрэнгүй ёсны зарчмыг удирдлага болгон коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Өршөөл үзүүлэх тухай хуулийг хэлэлцэн баталлаа.

Түүнчлэн 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр НҮБ-ын Мансууруулах Бодис, Гэмт Хэрэгтэй Тэмцэх Алба, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/, НҮБ-ын Дархлалын Олдмол Хомсдол /ДОХ/-ын Нэгдсэн Хөтөлбөр, НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газраас гаргасан “хорих анги болон бусад хаалттай орчин дахь Ковид-19” хамтарсан мэдэгдэлд төр засгийн зүгээс эрх чөлөө хасах, цагдан хорих явдлыг аль болох хязгаарлах, нэн ялангуяа хэт их ачаалалтай хорих байгууллагуудад хоригдож буй хоригдлуудын тоог бууруулах, хорих ялаас өөр төрлийн хариуцлагын арга хэмжээ авах хүчин чармайлтаа нэмэгдүүлэхийг уриалсныг хуулийг баталахад харгалзан үзлээ.

Өршөөл үзүүлэх тухай хууль 5 бүлэг, 13 зүйлтэй ба 2021 оны 7 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Өршөөл үзүүлэх тухай хууль нь 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 24 цаг 00 минутаас өмнө 2002 онд баталсан Эрүүгийн хууль болон 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 24 цаг 00 минутаас өмнө 2015 онд баталсан Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэрэг болон Зөрчлийн тухай хуульд заасан зарим зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хамаарах ба өршөөлд хамааруулах гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүний хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын болон шүүхээр хянан хэлэлцэх шатанд байгаа хэргийг хэрэгсэхгүй болгоно.

Ялаас өршөөн хэлтрүүлэхэд ялтан, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгоход яллагдагч гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн, эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн байна.

ФАТФ-ын зөвлөмжид нийцүүлэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, түүнчлэн дээрх гэмт хэргийн суурь гэмт хэрэг болох татвар төлөхөөс зайлсхийх, авлига, албан тушаалын гэмт хэрэг, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг зэрэг гэмт хэргийг өршөөлд хамааруулахгүй.

Мөн хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, эдийн засгийн гэмт хэрэг, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэргийг бүлгээр нь, хүнийг алах, галт зэвсэг хууль бусаар бэлтгэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг тариалах, худалдаалах, хэрэглэх орон байраар хангах, мөрийтэй тоглоом зохион байгуулах, нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах, байгаль орчныг бохирдуулах, соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах зэрэг 38 төрлийн гэмт хэргийг, өмчийн эсрэг гэмт хэрэг болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, цэргийн эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх зэрэг 19 төрлийн гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг өршөөлд хамааруулахгүй.

Түүнчлэн өмнө Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу хорих ялаас чөлөөлөгдсөнөөс хойш санаатай гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн хүнийг өршөөлд хамааруулахгүй. Өршөөлд хамруулахгүй гэмт хэргийг тодорхой тусгаж, хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хуулийн 7.4, 7.5, 9.4, 9.5, 9.6 дугаар зүйл заасны дагуу хэрэглэсэн албадлагын арга хэмжээг өршөөлд хамааруулахгүй.

Өршөөлд хамааруулахгүйгээс бусад гэмт хэрэг үйлдэж шүүхээс таван жил, түүнээс бага хугацаагаар хорих ял оногдуулсан, эсхүл эдлээгүй үлдсэн ял нь таван жил, түүнээс бага хугацаа үлдсэн бол хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солих бөгөөд хорих ялын эдлээгүй үлдсэн ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солиход ялтан нь байнга оршин суух газрын хаягтай байна.

Өршөөлд хамруулахгүй зааснаас бусад Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил үйлдэж оногдуулсан торгох, баривчлах шийдвэрийг гүйцэтгээгүй байгаа, эсхүл хэсэгчлэн гүйцэтгэсэн бол үлдсэн хэсгийг нэг удаа өршөөн чөлөөлөхөөр, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд холбогдуулан нээсэн зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгохоор тусгасан.

Харин Зөрчлийн тухай хуульд заасан Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчил, Үнэт цаас, банк, санхүү, гааль, татвар, мэргэжлийн хяналт, даатгалын журмын эсрэг зөрчил, гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих, хог хаягдлын тухай хууль зөрчих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих, садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зөрчих, хүүхдийн эрхийг зөрчих, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль зөрчих, Монгол Улсын хилийн тухай хууль зөрчих зэрэг нийт 2 бүлэг, 38 зөрчлийг өршөөлд хамааруулахгүй.

Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлд заасан зөрчил үйлдсэн хүн 2021 оны 10 дугаар сарын 01-ний дотор торгох шийтгэлийн төлбөрийн 50 хувийг төлсөн бол үлдсэн хувийг өршөөн чөлөөлнө.

Өршөөл үзүүлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хариуцлагаас өршөөн хэлтрүүлсэн, чөлөөлсөн, хэрэгсэхгүй болгосон, мөн зөрчлийн шийтгэлээс өршөөн чөлөөлсөн, зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон нь хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирол, хор уршгийг нөхөн төлөх үүргээс чөлөөлөхгүй бөгөөд хохирогч, иргэний нэхэмжлэгч холбогдох хуульд заасан журмын дагуу нэхэмжлэл гаргах эрхтэй.

Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу хорих ялаар шийтгүүлсэн 4175 хоригдлоос 160 гаруй хоригдол ялаас бүрэн чөлөөлөгдөж, 1130 хоригдлын хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солих, 180 орчим хоригдлын хорих ялаас 2 жилийг хасаж, өсвөр насны 25 хүн, нийт 1800 орчим буюу нийт хоригдлын 46.4 хувь нь хамрагдана.

Түүнчлэн хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн 3682 ялтнаас өршөөлд хамааруулахгүй гэмт хэрэг үйлдэж торгох ял шийтгүүлсэн 118, нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн 6, эрх хасах нэмэгдэл ял шийтгүүлсэн 2, нийт 126 ялтан байна.

Мөн хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн 2500 орчим, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 160, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоосон 1200 гаруй, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 160, нийт 4000 гаруй этгээд хамрагдана. Торгох шийтгэлтэй 193, хохирол нөхөн төлбөр гаргуулах, хөрөнгө, орлогыг хураах 74 албадлагын арга хэмжээ авагдсан хүн, хуулийн этгээд үлдэхээр байна.

**ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ****Нэг.Хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл, практик шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд өршөөл үзүүлэх шийдвэр гаргах онцгой бүрэн эрхийг зөвхөн Улсын Их Хурал хэрэгжүүлэхээр заасан бөгөөд хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилгыг Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан байдаг.

Дээрх бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурал 1991, 1996, 2000, 2006, 2009, 2015 онд буюу нийт 6 удаа Өршөөл үзүүлэх тухай хуулийг баталсан ба 2015 оны Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуулиар зарим этгээдийг захиргааны буюу зөрчлийн шийтгэлээс чөлөөлж байсан болно. Үүнд:

1991 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн “Өршөөл үзүүлэх тухай” хуулиар ял эдэлж байсан нийт 4936 ялтнаас 1321 буюу 27 хувь нь суллагдаж, 499 ялтан буюу 10 хувь нь эдлээгүй үлдсэн ялаас зохих журмын дагуу хэсэгчлэн хасуулсан ба нийт ялтны 63 хувь буюу 3116 ялтан өршөөлд хамрагдаагүй.

1996 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн “Өршөөл үзүүлэх тухай” хуулиар ял эдэлж байсан нийт 6093 ялтнаас 200 ялтан буюу 3,3 хувийг суллаж, 22 ялтан буюу 0,4 хувийг нь эдлээгүй үлдсэн ялаас хэсэгчлэн хасаж, 5871 ялтан буюу 96,3 хувь нь өршөөлд хамрагдаагүй, энэхүү хуулиар зөвхөн насанд хүрээгүй этгээд, эмэгтэйчүүд, 60 ба түүнээс дээш насны эрэгтэйчүүд хамрагджээ.

2000 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн “Өршөөл үзүүлэх тухай” хуулиар нийт ял эдэлж байсан 6734 ялтны 14,6 хувь буюу 985 ялтныг суллаж, 13 хувь буюу 877 ялтны эдлээгүй үлдсэн ялаас тодорхой хувиар өршөөн хасаж, 72,4 хувь буюу 4872 ялтан өршөөлд хамрагдаагүй байна.

2006 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн “Өршөөл үзүүлэх тухай” хуулиар нийт 7504 ялтны материал хэлэлцүүлсэнээс 30,8 хувь буюу 2318 ялтан суллагдаж, 19,5 хувь буюу 1469 ялтны эдлээгүй үлдсэн ялаас зохих хэмжээгээр хасаж, 3717 ялтан буюу 49,5 хувь нь хамрагдаагүй байна.

2009 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Өршөөл үзүүлэх тухай” хуулиар 7640 ялтнаас 31,9 хувь буюу 2440 ялтныг суллаж, 10,8 буюу 831 ялтны эдлээгүй үлдсэн ялаас хасаж, 3271 ялтан буюу 42,8 хувь нь өршөөлд хамрагдаагүй байна.

2015 оны хуулиар ял эдэлж байсан нийт 6680 ялтнаас 3671 нь буюу 54,9 хувь нь өршөөлийн хуульд хамаарагдаж, шүүхээр шийдвэрлүүлсэн байна.

2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр НҮБ-ын Мансууруулах Бодис, Гэмт Хэрэгтэй Тэмцэх Алба, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/, НҮБ-ын Дархлалын Олдмол Хомсдол /ДОХ/-ын Нэгдсэн Хөтөлбөр, НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газраас гаргасан “хорих анги болон бусад хаалттай орчин дахь Ковид-19” хамтарсан мэдэгдэлд

төр засгийн зүгээс эрх чөлөө хасах, цагдан хорих явдлыг аль болох хязгаарлах, нэн ялангуяа хэт их ачаалалтай хорих байгууллагуудад хоригдож буй хоригдлуудын тоог бууруулах, хорих ялаас өөр төрлийн хариуцлагын арга хэмжээ авах хүчин чармайлтаа нэмэгдүүлэхийг уриалсан. Тэр дундаа өндөр настай, суурь өвчтэй хүмүүс, түүнчлэн хөнгөн гэмт хэрэг үйлдсэн, олон нийтийн аюулгүй байдалд заналхийлэхгүй хүмүүс болон эмэгтэйчүүд, хүүхдүүдэд онцгой анхаарал хандуулахыг тэмдэглэсэн.

Мөн НҮБ-ын Хүүхдийн сангийн гүйцэтгэх захирал Хенриетта Фор 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр гаргасан мэдэгдэлдээ Засгийн газрууд болон бусад саатуулах байрны эрх баригчдыг аюулгүй орчинд суллагдах боломжтой бүх хүүхдийг яаралтай суллахыг уриалсан байна.

Хорих анги, байгууллагуудын хувьд олон хүн нэг байранд төвлөрч, хоол бэлтгэх, түгээх, угаалга, ариутгалын ажил нэгдсэн байдлаар зохион байгуулагддаг, хоригдол, хоригдсон этгээдийг биечилсэн хяналт тавьж ажиллаж буй алба хаагчид нийгмийн харилцаанд оролцож, халдвар авах, тээх эрсдэлтэй тул шинэ коронавирусын халдвар илэрсэн тохиолдолд богино хугацаанд олон хүнийг хамран тархах, улмаар жирэмсэн болон нярай хүүхэдтэй эмэгтэйчүүд, биеийн дархлаа сул, архаг хууч өвчтэй, өндөр настай хоригдол, хоригдсон этгээд хүндээр өвчилж, хүний амь нас эрсдэх нөхцөл байдал үүсэж байна.

Түүнчлэн Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш буюу 2021 оны байдлаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зааснаар 31 байгууллагын 10.775 орчим субъект зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж байна.¹

Зөрчлийн тухай хууль хэрэгжих хугацаанд тухайн жилд бүртгэгдсэн нийт зөрчлийн 95 дээш хувийг Цагдаагийн байгууллага харьяалан шалган шийдвэрлэсэн бөгөөд бүртгэгдсэн зөрчлийг Зөрчлийн тухай хуулийн зүйл, хэсгээр нь үзвэл 6.696.529 буюу 93.0 хувь нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих /14.7/, 257.071 буюу 3.5 хувь нь Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах /5.1/, 18.238 буюу 0.2 хувь нь Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих /10.4/, 30.406 буюу 0.4 хувь нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих /5.4/, 14.715 буюу 4.4 хувь нь Танхайрах /5.2/, 2.681 буюу 0.03 хувь нь Тамхины хяналтын тухай хууль зөрчих /6.3/, 280.907 буюу 3.8 хувь нь бусад төрлийн зөрчил эзэлж байна.²

Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2021 оны эхний 05 сарын байдлаар цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд нь бэлэн бус хэлбэрээр нийт 6.154.933 удаагийн 168 тэрбум 648 сая төгрөгийн торгох шийтгэл оногдуулснаас 3.035.324 удаагийн 73 тэрбум 339 сая төгрөг, шүүхийн шийдвэрийн дагуу 1.9 тэрбум төгрөгийн торгох шийтгэл тус тус төлөгдөөгүй байна.

Иймд дээрх нөхцөл байдлыг харгалзан тулгар төр байгуулагдсаны 2230, Их Монгол Улсын 815, Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан хүмүүнлэг, энэрэнгүй ёсны зарчмыг удирдлага болгон коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор зарим гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлага, зөрчлийн болон бусад шийтгэлээс нэг удаа өршөөн хэлтрүүлэх, чөлөөлөх, хасах, шүүхээс оногдуулсан ялын төрлийг солих нь зүйтэй гэж үзэж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

¹ Улсын Ерөнхий Прокурорын газрын бүртгэлийн мэдээллээс 2021 он

² Цагдаагийн ерөнхий газрын зөрчлийн хэргийн талаарх мэдээлэл 2021 он

Хорих анги, байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар хоригдож буй 4175, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан 1045, баривчлах шийтгэл эдэлж буй 177, хорихоос өөр төрлийн ялаар 3669, албадлагын арга хэмжээ авагдсан 3984, нийт 13050 ялтан /хоригдол/, хоригдсон этгээдэд байгаа бөгөөд зөвхөн хоол хүнсэнд өдөрт нэг хүнд 6000-8000 төгрөг зарцуулж байна.³

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор өршөөлд хамруулахгүй болон ялаас хасах, хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солихоор зааснаас бусад гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдож оногдуулсан болон биечлэн эдэлсэн хорих болон хорихоос өөр төрлийн ялын хугацааг үл харгалзан эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас өршөөн хэлтрүүлэхээр тусгана.

Ялаас өршөөн хэлтрүүлэхэд ялтан хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр тогтоосон гэмт хэргийн хохирлын тодорхой хувийг нөхөн төлж, бусад хэсгийг нөхөн төлөхөө илэрхийлсэн байх, өршөөлд хамруулахгүй болон ялаас хасах, хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солихоор зааснаас бусад хөнгөн гэмт хэрэг үйлдэж Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.2 дахь заалт, 7.1 дүгээр зүйлд заасан журмын дагуу тэнссэн, мөн хуулийн 7.6 дугаар зүйлд заасан хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, 8.6 дугаар зүйлд заасан өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацааг тус тус өршөөн хэрэгсэхгүй болгоно.

Түүнчлэн Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэрэг үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээсэн ялтны оногдуулсан ялаас, эсхүл эдлээгүй үлдсэн хорих ялаас хоёр жилийг хасахаар тусгах бөгөөд хорихоос өөр төрлийн ял оногдуулсан бол торгох ялын арван таван нэгжийг, нийтэд тустай ажил хийлгэх ялын 8 цагийг, зорчих эрхийг хязгаарлах ялын 1 өдрийг хорих ялын нэг хоногоор тооцож ялтны ялаас дүйцүүлэн хасна.

Өршөөлд хамруулахгүй гэмт хэргийг тодорхой тусгаж, хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хуулийн 7.4, 7.5, 9.4, 9.5, 9.6 дугаар зүйл заасны дагуу хэрэглэсэн албадлагын арга хэмжээг өршөөлд хамааруулахгүй.

Мөн ФАТФ-аас Монгол Улсыг “Саарал” жагсаалтад оруулсантай холбогдуулан Европын Холбооны хар жагсаалт буюу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтад оруулж байсан. Монгол Улс дээрх 2 жагсаалтад дахин орохгүйн тулд ФАТФ-ын зөвлөмжийн 3, 5, 35 болон шууд хэрэгжилтийн 7-д нийцүүлэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, татвар төлөхөөс зайлсхийх, хулгайлах, дээрэмдэх, залилах, хөрөнгө завших, хүрээлэн байгаа орчны эсрэг зэрэг гэмт хэргүүдийг өршөөлд хамааруулахгүй байхаар тусгана.

Өршөөлд хамааруулахгүй зааснаас бусад Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил үйлдэж оногдуулсан торгох, баривчлах шийдвэрийг гүйцэтгээгүй байгаа, эсхүл хэсэгчлэн гүйцэтгэсэн бол үлдсэн хэсгийг нэг удаа өршөөн чөлөөлөхөөр, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд холбогдуулан нээсэн зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгохоор тусгана.

Хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн 4.1, 4.2, 4.3, 4.4 дүгээр зүйлд заасны дагуу хэрэглэсэн албадлагын арга хэмжээг өршөөлд хамааруулахгүй бөгөөд хууль хэрэглэх журмыг тусгана.

³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын мэдээлэл 2021 он

2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө үндэсний их баяр наадмын тухай хууль тогтоомжид заасны дагуу үндэсний бөхийн барилдаан болон сур харваанд оролцох эрхээ хасуулсан бөх, сурын харваачийн үндэсний их баяр наадамд оролцох эрхийг нэг удаа өршөөн сэргээхээр тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар нэг дор олноороо байгаа хүмүүст коронавирусын халдвар тархахаас урьдчилан сэргийлэх, хорих болон цагдан хорих, баривчлах байрны ачаалал буурна.

Мөн хуулийн төсөл батлагдсанаар хоригдол, баривчлах шийтгэл эдэлж буй этгээдийн зөвхөн хоол хүнсний зардлаас 1.7 тэрбум төгрөг хэмнэж, үлдсэн хоригдлыг хорих анги, байгууллагын хоригдлын байрны багтаамжид нийцүүлэн тараан байршуулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдснаар хүмүүнлэг, энэрэнгүй ёсны зарчмыг хангах төдийгүй Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл буруулах томоохон алхам болох буюу иргэд, хуулийн этгээдэд санхүүгийн бодит дэмжлэг болно гэж үзэж байна.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн боловсруулна.

Энэхүү хуулийн төсөлтэй холбогдуулж хууль хүчингүй болгох, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, төсөвт тодотгол хийх шаардлагагүй болно.

---oOo--

